

ШИНЭ МЭДЭЭ

**МОНГОЛ ДАХЬ СОЛОНГОС  
СУДЛАЛЫН ТӨВ**

Монголын зарим эрдэмтэн, судлаач, их, дээд сургуулийн багш нар болон солонгосын талтай ажил төрлийн харилцаатай байгууллагын ажилтнууд, Солонгосыг сонирхогчдын үүсгэл санаачилгаар 1990 оны тавдугаар сард ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн дэргэд Монголын солонгос судлалын Төв байгуулагдан ажиллаж байна.

Тус төвийн зорилго нь олон мянган жилийн түүхтэй солонгос үндэстний түүх, хэл, соёл, тэрчлэн монгол-солонгосын ард түмний харилцааны түүхэн өв уламжлал, өнөөгийн байдал, хэтийн төлөвийг судлахын зэрэгцээгээр солонгосын ард түмний цогцлон байгуулагч ололт амжилт, түүний дотор. «Азийн дөрвөн бар»-ын нэг БНСУ-ын эрчимтэй хөгжлийн туршлагаас судлан монгол орныхоо хөгжил, дэвшилд тодорхой хувь нэмэр оруулахад оршино.

Үүнээс гадна Ази, Дорнодахины улс түмний уран зохиолын арвин их сан хөмрөгт өөрийн гэсэн өвөрмөц өнгө аясыг бий болгосон солонгосын уран зохиолоос орчуулах, солонгосоор мэргэжих хүмүүст хэлний анхан шатны мэдлэг эзэмшүүлэх, хоёр орны эрдэмтэд, судлаачид, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд ажил төрлийн хэлхээ холбоо тогтоох явдал төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг байх болно.

Төв байгуулагдаад төдийлөн удаагүй хэдий ч солонгосын болон гадаад орнууд дахь ижил төрлийн байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоож, солонгос хэлний дамжаа нээн, эрдэм шинжилгээ, уран зохиолын чиглэлээр орчуулга хийн ажиллаж буй сацуу 1990 оны арван хоёрдугаар сард эрдэм шинжилгээний анхныхаа хурлыг хийж, БНСУ-ын хөгжил байдал, монгол-солонгосын харилцааны түүхэн зарим үйл явдлыг тусгасан телевизын баримтат кино хийж нэвтрүүлээ. Монгол-Өмнөд Солонгосын найрамдлын нийгэмлэгтэй хамтран зохиосон дээрх эрдэм шинжилгээний хуралд доктор Ч. Далай, дэд эрдэмтэн Т.Дүгэрсүрэн, Ж. Баясах, багш Р.Чүлтэмсүрэн, зохиолч Лха. Дарьсүрэн, монголыг судлаач Кей Ро Ий нарын олон хүн монгол-солонгосын эртний харилцаа болон түүх, соёл, хэл, уран зохиолын хол богдолтой сонирхолтой илтгэл оруулж хэлэлцүүлэв. Уг хуралд Хельсинкийн их сургуульд багшилж буй БНСУ-ын профессор Ко Сон Му болон манай оронд суралцаж байгаа БНСУ-ын аспирант, судлаач, оюутнууд түүнчлэн тус улсад суугаа БНСУ-ын ЭСЯ-ны ажилтнууд оролцож илтгэлүүдтэй холбогдуулан санал бодлоо солилцож ярилцсан юм.

Эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг дэмжин тэтгэх БНСУ-ын фонд зэрэг холбогдох байгууллагууд, Улаанбаатар дахь БНСУ-ын ЭСЯ, ялангуяа ноён Элчин сайд Квон Ён Сун судалгааны эх хэрэглэгдэхүүнээр хангах болон бусад талын тусламж үзүүлэх, лекц унших зэргээр тус төвийн үйл ажиллагаанд бодитой тус дэмжлэг үзүүлж байгааг энэ дашрамд тэмдэглэхэд таатай байна.

Солонгос судлалыг бие даасан судлал болгон хөгжүүлэх эх үүсвэрийг тавьсан Монголын солонгос судлалын Төв цаашид улам өргөжин монгол, солонгосын ард түмний харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг бэхжүүлж, тэдний соёл, шинжлэх ухааны салбар дахь хэлхээ холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд зохих хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

**Б. Лхагваа**